



**БИДНИЙ ЁС ЗҮЙ
БА**

АЖИЛ ХЭРГИЙН ЗАН ТӨЛӨВИЙН ДҮРЭМ



orano

1	Бидний үнэт зүйлс ба зарчмууд	04
2	Ёс зүй ба хуулийн нийцэл	05
3	Оролцогч талуудын харилцаа	05
	Группийн үйл ажиллагаа явуулдаг улс орнууд, төлөөллүүд, захиргааны ба эрх бүхий байгууллагууд	05
	Үйлчлүүлэгч ба түншүүд	05
	Ажиллах хүч ба тэдний төлөөлөл	06
	Хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчид	06
	Ханган нийлүүлэгчид болон гэрээлэгчид	06
	Олон нийт болон бүс нутаг	07
4	Хүн ам, хүрээлэн буй орчин ба бидний нөөц баялагийг хамгаалахад чиглэдэг манай бодлого	07
	Хувь хүн болон хүний эрхийг хүндэтгэх	07
	Аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, хүрээлэн буй орчин болон эрүүл мэндийг хамгаалах	08
	Чанар	08
	Нэр хүнд ба дүр төрх	08
	Биет бус хөрөнгө	09
	Хувь хүний мэдээллийг хамгаалах	09
5	Бидний ажил хэргийн зан төлөвийн дүрэм	10
	Авлига ба зүй бус нөлөөлөл	10
	Мөнгө угаах	11
	Ажил хөнгөвчилсний төлбөр	11
	Бэлэг дурсгал ба урилга	12
	Ашиг сонирхлын зөрчил	12
	Өрсөлдөөний тухай хууль	13
	Экспортын хяналт ба олон улсын хориг арга хэмжээ	13
	Гуравдагч талуудын харилцаа	13
	Сонирхлын төлөөлөл ба улс төрийн санхүүжилт	14
	Ивээн тэтгэлэг, хандив болон хүмүүнлэгийн үйл ажиллагаа	14
	Инсайдер арилжаа	15
	Залилан	15
6	Шүгээл үлээх систем	16
7	Сахилгын шийтгэл	16

Орано групп нь дэлхийн олон оронд үйл ажиллагаа явуулдагийн хувьд нарийн төвөгтэй нөхцөлд ажилладаг. Энэ утгаараа “Одоо ба ирээдүйд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг эрүүл бас байгалийн нөөцийг зохистой ашигладаг дэлхийн төлөө цөмийн материалыг хувиргах ба хянах хамгийн шилдэг мэдлэг туршлага, ур чадварыг хөгжүүлэх” группийн зорилготой уялдсан зорилго зорилт, урт хугацааны тогтвортой байдлыг хангасан стратегийн үүрэг амлалт нь бидний үйлдэл, хандлагыг бүх түвшинд хийгээд бүхий л үйл ажиллагаанд удирдан чиглүүлдэг нийтлэг үнэт зүйлс дээр тулгуурладаг. Үүнд:



Эдгээр үнэт зүйлсийг өдөр тутмын үйл ажиллагаандаа удирдлага болгохын тулд дагаж мөрдөх ёстой зарчим ба дүрмийг энэхүү «Ёс зүй ба ажил хэргийн зан төлөвийн дүрэм»-д тодорхойлсон. Уг дүрэм нь бидний соёлын тусгал бөгөөд, ялангуяа тогтвортой хөгжлийг дэмжих, хүний эрхийг дээдлэх тал дээр оролцогч талуудын өмнө хүлээсэн бидний үүрэг амлалтыг илэрхийлдэг. Энэхүү дүрэм нь манай нийт ажилтан, удирдлагуудад зориулсан гарын авлага болох бөгөөд бидний үйл ажиллагааг амжилттай байлгахыг зорьж буй хүн бүрээс бидний хүлээх үр дүн, түүнд тавигдах шаардлагыг тодорхойлдог.

Группийн дотоод сүлжээнээс гадна гадны порталаас танилцах боломжтой энэхүү дүрмээр групп нь авлига, хууран мэхлэлтийн бүх хэлбэрийг үл тэвчих зарчим ба үүрэг амлалтаа дахин баталж байна.

Оролцогч талуудын өмнө үүрэг хүлээсэн хариуцлагатай компанийн хувьд бидний үйл ажиллагаа дараах нэн тэргүүний хоёр зарчимд тулгуурладаг. Үүнд:

- **Үйл ажиллагаандаа цөмийн ба хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, эрүүл мэнд болон байгаль орчныг хамгаалах асуудлаар хамгийн өндөр стандартуудыг хэрэгжүүлэх,**
- **Авлига, хууран мэхлэлт болон өрсөлдөөнийг хязгаарласан аливаа үйл ажиллагаатай тууштай тэмцэх асуудлаар хамгийн хатуу хэм хэмжээг дагаж мөрдөх.**

Эдгээр үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлж, бидний зарчмуудыг баримтлан ажиллах нь дэлхий даяарх группийн нийт ажилтан, удирдлагуудаас гадна үйлдвэрлэл ба худалдааны түншүүдийн үүрэг юм.

Гүйцэтгэх хороо, төлөөлөн удирдах зөвлөл болон бидний зүгээс энэхүү ёс зүй ба ажил хэргийн зан төлөвийн дүрмийг чандлан дагаж мөрдөнө хэмээн та бүхэнд найдаж байгаа бөгөөд ингэснээр бид бүгд үйлчлүүлэгч, түншүүддээ үнэ цэнийг бүтээхийн зэрэгцээ тогтвортой бөгөөд үр ашигтай өсөлтийн суурийг хамтдаа тавьж чадна.

Николас Мэйс
Ерөнхий захирал

Клод Имовен
Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

1 Бидний үнэт зүйлс ба зарчмууд

Энэхүү дүрэмд “Одоо ба ирээдүйд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг эрүүл бас байгалийн нөөцийг зохистой ашигладаг дэлхийн төлөө цөмийн материалыг хувиргах ба хянах хамгийн шилдэг мэдлэг туршлага, ур чадварыг хөгжүүлэх” бидний зорилт болон стратегийн үүрэг амлалттай уялдуулан группийн үнэт зүйлсүүдийг тодорхойлсон. Группийн үйл ажиллагаа явуулж буй дэлхийн аль ч өнцөгт, ямар ч нөхцөлд энэхүү дүрэм нь ажилтан нэг бүрийн дагаж мөрдөх ёстой зан төлөв ба үйлдлийн жишиг байх ёстой. Нийт ажилтнууд дангаараа болон хамтдаа энэхүү ёс зүйн үүрэг амалтыг өдөр тутмын үйл ажиллагаандаа баримтлах ёстой.

Орано группийн хэмжээнд бид бүгд дараах нийтлэг үнэт зүйлсийг эрхэмлэдэг. Үүнд:

-  **Цөмийн ба хөдөлмөрийн аюулгүй байдал:** Дүрэм журмыг баримтлаагүй нэг ч үйлдэлтэй эвлэрэхгүй, хамгийн өндөр стандартыг хэрэгжүүлэхийг эрмэлзэх;
-  **Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж:** Анхаарал хандуулах, бодит байдлыг ойлгож уян хатан байх, урьдчилан таамаглах, түргэн шуурхай байх, идэвхи санаачилгатай байх;
-  **Тасралтгүй сайжруулалт:** Эрх мэдэл олгож байх, алдаа гаргах эрхийг олгох, санаачилгатай, бүтээлч байх, үр дүнд анхаарах, гадаад харилцаа холбоо тогтоох, сорилт бэрхшээлтэй нүүр тулж давах;
-  **Хүндлэл ба хувь хүний хөгжил:** Анхааралтай байх, өндөр хэм хэмжээг баримтлах, нөхөрсөг харилцах, ялгаатай байдлыг хүндэтгэх, хувийн болон мэргэжлийн хувьд хөгжих;
-  **Багийн тоглолт ба уялдаа холбоо:** Хамтарч ажиллах, ил тод байх, асуудал шийдвэрлэх, багаар ажиллах;
-  **Ёс зүй, ил тод байдал ба хамтран ярилцаж байх:** Дотоод ба гадаад оролцогч талуудтай мэдээлэл солилцох ба яриа хэлэлцээ хийх, хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөх, ажилтнуудын эрхийг хүндэтгэх, үлгэр жишээ байх, шударга байх.

Орано групп нь ёс зүй, хуулийн нийцлийг дээд хэмжээнд хангаж ажилладаг хариуцлагатай компани юм. Орано групп нь үйл ажиллагаа явуулахдаа Нэгдсэн Үндэстний Байгууллагаас баталсан “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-д тодорхойлсон хүний эрхүүдийг дээд зэргээр хүндэтгэдэг.

Орано групп нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын «Даян Дэлхийн Гэрээ»-ний зарчмуудыг хэрэгжүүлдэг. Түүнчлэн ЭЗХАЗБ-ын Үндэстэн дамнасан корпорациудад зориулсан Удирдамжуудыг хэрэгжүүлж, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг дэмждэг.

Орано групп нь үйл ажиллагаа явуулж буй улс орнуудын хууль журмуудаас гадна компанийн дотоод дүрэм журмуудыг чандлан мөрддөг. Ажилтнуудынхаа эрхийг дээд зэргээр хүндэтгэх үүрэг хүлээдэг төдийгүй Орано групп нь ямар ч нөхцөлд холбогдох хамгийн дээд хэм хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг эрмэлздэг.

Үнэнч шударга байх, яриа хэлэлцээнд нээлттэй, ил тод байх, цөмийн ба хөдөлмөрийн аюулгүй байдлыг дээд зэргээр хангах зэрэг гол үнэт зүйлсүүдийг ямар ч нөхцөлд шийдвэр гаргахдаа баримталдаг.

Байгаль орчин, эдийн засаг ба нийгмийн хариуцлагын чиглэлээр гүйцэтгэлийн үзүүлэлтээ бодитоор үнэлэхийн тулд Орано групп нь найдвартай, үнэн зөв мэдээллээр хангах зарчмыг баримталдаг.

Энэхүү дүрэм нь Орано группийн нийт ажилтнуудаас гадна гадны болон түр ханган нийлүүлэгчдэд үйлчилнэ. Одоогийн хууль тогтоомжоор шаардаж байвал илүү хатуу журмаар тус дүрмийг орлуулахгүй.

Баримталвал зохих болон хориотой зан төлөвийн жишээг сэдэв тус бүрээр оруулсан.

2 Ёс зүй ба хуулийн НИЙЦЭЛ

Орано группийн «Ёс зүй ба ажил хэргийн зан төлөвийн дүрэм»-ийг (Мөн “Ёс зүйн дүрэм” гэж нэрлэдэг) дагаж мөрдөх нь ажилтан нэг бүрийн үүрэг юм. Удирдах түвшний ажилтнууд ёс зүй ба зан төлөвийн хувьд үлгэр жишээч байна.

Удирдах түвшний ажилтнууд нь ёс зүй ба хуулийн нийцлийн хөтөлбөрт хяналт тавьж, Хуулийн нийцлийн хэлтэсээс гадна тус дүрэмд тусгагдсан асуудлаар холбогдох бусад хэлтсүүдийн дэмжлэгтэйгээр группийн хэмжээнд ёс зүйн соёлыг түгээн дэлгэрүүлэхэд хүчин чармайлт гаргаж ажиллана.

Удирдах түвшний ажилтнууд буюу менежерүүд нь ёс зүй болон хуулийн нийцэлтэй холбоотой багийн гишүүдийнхээ асуултад хариулах эсвэл өөрийн нэгж, хэлтсийн хуулийн нийцлийн ажилтанд асуултыг дамжуулна. Хуулийн нийцлийн хэлтэс нь мөн нийт ажилтнуудын ёс зүйн холбогдолтой асуултанд хариулна.

Ажилтнууд дотоод сүлжээнээс сэдэв тус бүрээр зурагт тайлбар бүхий «Ёс зүй ба хуулийн нийцэл: Би юу хийх ёстой вэ?» хэрэглээний гарын авлагатай танилцах боломжтой бөгөөд гарын авлагыг группийн бодлого, журамд суурилж боловсруулсан.

Орано групп нь энэхүү дүрэм эсвэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бодлого, журмын хэрэгжилтийг хангах зорилгоор тодорхой хяналт шалгалтуудыг зохион байгуулж болно.

3 Оролцогч талуудын харилцаа

Орано групп нь оролцогч талуудынхаа өмнө хүлээсэн үүрэг амлалтуудаа өөрийн үнэт зүйлс болон зарчмууддаа тусгасан. Мөн группийн зүгээс үйлдвэрлэлийн ба бизнесийн түншүүд, ялангуяа ханган нийлүүлэгч болон гэрээлэгчид уг дүрмийг дагаж мөрдөж байгаад хяналт тавидаг.

Группийн үйл ажиллагаа явуулдаг улс орнууд, төлөөллүүд, захиргааны болон эрх бүхий байгууллагууд

Орано групп нь үйл ажиллагаагаа явуулж буй улс орнуудад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж болон дүрэм журмуудыг дагаж мөрддөг бөгөөд үүнд аюулгүй ажиллагааны асуудал эрхэлсэн байгууллагуудын зааварчилгаа мөн багтана.

Үйлчлүүлэгч ба түншүүд

Үйлчлүүлэгчдийнхээ сэтгэл ханамжид тогтмол анхаарснаар тэдний хүлээлтийг урьдчилан таньж, биелүүлэх боломжтой байдаг. Бид өндөр чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх замаар үйлчлүүлэгчдийнхээ өмнө хүлээсэн үүрэг амлалтаа биелүүлэхийг эрмэлздэг.

Бид үйлчлүүлэгчдийнхээ соёлыг хүндэтгэж, тэдний дүр төрх, ашиг сонирхлыг хамгаалдаг. Орано групп нь хууль тогтоомж ба гэрээний үндсэн дээр үйлчлүүлэгч ба түншүүдийнхээ бидэнтэй хуваалцаж буй мэдээлэл эсвэл ноу-хауг өөрийн мэт хамгаалж, нууцлалыг хангадаг.

Ажиллах хүч ба тэдний төлөөлөл

Орано группийн ажиллах хүчний бүрэлдэхүүнд гүйцэтгэх захирлууд, удирдах түвшний ажилтнууд, ажилтнууд, дадлагажигч ажилтнууд болон дадлагын оюутнууд багтана. Ялангуяа гүйцэтгэх захирлууд болон удирдах түвшний ажилтнууд үлгэр жишээ зан төлөвтэй байх үүрэгтэй.

Орано групп нь ажилтан сонгон шалгаруулж авахдаа нас, гарал үүсэл, хүйс, бэлгийн чиг баримжаа, үндэс угсаа, шашин шүтлэг, улс төрийн үзэл баримтлал, гадаад төрх эсвэл хөгжлийн бэрхшээл зэргээр нь ялгаварлан гадуурхдаггүй.

Орано групп нь ажилтнуудынхаа хувийн эрх чөлөөг хүндэтгэдэг ба улс төрийн үзэл баримтлал, эвлэлдэн нэгдсэн байдал болон философийн эсвэл шашны итгэл үнэмшлийн тухайд төвийг сахисан байр сууринаас ханддаг. Харин ажлын байран дахь аливаа ухуулга сурталчилгааг хориглодог.

Орано групп нь чин сэтгэлийн, үнэнч шударга хөдөлмөрийн харилцааг хөгжүүлэн бэхжүүлэхийг эрмэлздэг.

Групп нь ажилтнуудаа ажил үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай бүх чиглэлээр мэдлэг, ур чадвараа хөгжүүлэхэд чилэсэн сургалтын хөтөлбөрүүдийг санал болгодог бөгөөд энэ нь тэдэнд мэргэжлийн хувьд өсөж дэвших боломж олгодог.

Группийн ажилтан нэг бүр Нэгдсэн Үндэсний Байгууллагаас баталсан Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалд тодорхойлсон Хүний Эрхүүдийг дээд зэргээр хүндэтгэдэг.

Ажилтнууд ямар ч нөхцөл үнэнч шударгаар ажиллаж, тухайн улсад үйлчилж буй хууль тогтоомжуудаас гадна Орано группийн Ёс зүй ба ажил хэргийн зан төлөвийн дүрэм болон группийн бусад бодлого, журмуудыг мөрдөж ажиллах үүрэгтэй. Ажилтнууд Орано группийн хөрөнгийг өөрийн мэт үзэж, зохистой удирдах ба энэхүү шаардлага нь түргэрээтэй ажилтнуудад ижил хэмжээнд тавигдана.

Ажилтнууд нь группийн гол үнэт зүйлсүүд болон зарчмуудыг хүндэтгэж, группийн зүгээс хүлээсэн үүрэг амлалтыг биелүүлж ажиллана.

Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж нь группийн ажилтнуудыг хөдөлгөгч хүч байна. Орано группийн ажилтнууд ажлын өндөр ёс зүй, ур чадвараас гадна чанга хатуужилтай байна. Ажилтнуудын гүйцэтгэж байгаа ажил, мөн гэрээлэгчээр гүйцэтгүүлж байгаа ажил үйлчилгээ ул мөртэй буюу хяналт тавих боломжтой байх ёстой.

Группийн ажилтнууд Орано группийн бүтээгдэхүүн, үйлчилгээг чанарын өндөр түвшинд үзүүлэхэд анхаарч ажиллана. Орано группийн ажилтнууд группийн үйл ажиллагаанд тустай мэдлэгийг шилжүүлэн нэвтрүүлэх ба бидний тасралтгүй сайжруулалтын зарчмын дагуу хүлээн авсан санал хүсэлт, гомдлыг шат дараатайгаар хүлээн авч, арга хэмжээ авч ажиллана.

Хувьцаа эзэмшигчид ба хөрөнгө оруулагчид

Орано групп нь компанийн засаглалын зарчмуудыг хэрэгжүүлэх, ялангуяа хувьцаа эзэмшигч ба хөрөнгө оруулагчдынхаа хөрөнгө оруулалтын бодит өгөөжийг нэмэгдүүлэхийг зорьдог. Хувьцаа эзэмшигч ба хөрөнгө оруулагчидтайгаа ижил тэгш харилцаж, санхүүгийн зохистой, үнэн зөв мэдээллээр хангахад онцгой анхаардаг.

Ханган нийлүүлэгчид ба гэрээлэгчид

Орано групп нь үйлчлүүлэгчиддээ стандартын өндөр түвшинд үйлчилгээ үзүүлэх үүднээс ханган нийлүүлэгчид болон гэрээлэгчидтэйгээ шударга өрсөлдөөний хүрээнд түншлэлийн тогтвортой харилцааг бэхжүүлж ажиллахыг эрмэлздэг.

Тийм учраас нийт ханган нийлүүлэгчид, гэрээлэгчид болон түншүүдтэйгээ харилцан хүндэтгэлийн зарчимд тулгуурласан үнэнч шударга, бодитой харилцааг бэхжүүлж ажиллахыг зорьдог.

Орано групп нь ханган нийлүүлэгчдийнхээ нэр хүнд, мэдээллийн нууцлалыг нь өөрийн мэт хамгаалдаг.

Орано групп нь өөрийн ханган нийлүүлэгчид, гэрээлэгчид, санхүүгийн түншүүд, зөвлөхүүд болон дистрибьютерүүд, агентууд зэрэг борлуулалтын зуучлагчид нь үйл ажиллагаандаа энэхүү Ёс зүй ба ажил хэргийн зан төлөвийн дүрэмд тодорхойлсон зарчмуудыг баримталж байгаад хяналт тавьж ажиллахыг зорьдог.

Орано групп нь хүний эрхийн талаарх олон улсын хууль тогтоомжийг хүндэтгэн сурталчилж, дагаж мөрдөхийн зэрэгцээ хүний наймаа, албадан болон хүчээр хөдөлмөр эрхлүүлэх эсвэл хүүхдийн хөдөлмөрийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд ханган нийлүүлэгчид болон гэрээлэгчиддээ тус шаардлагыг мөн тавьдаг.

Түүнчлэн Орано групп нь ханган нийлүүлэгчидээ өөрийн харуул хамгаалалт, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдал болон байгаль орчин хамгааллын стандартуудыг үйл

ажиллагаандаа мөрдлөг болгох эсвэл дор хаяж ижил түвшний өөр бусад стандартуудыг нэвтрүүлж ажиллах шаардлагыг тавьдаг.

Орано групп нь нийлүүлтийн сүлжээн дэх өөрийн ханган нийлүүлэгчид болон гэрээлэгчидийн үйл ажиллагаа нь Орано группийн Ёс зүй ба ажил хэргийн зан төлөвийн хүрээнд явагдаж байгаа эсэхэд хэдийд ч хяналт шалгах хийх эрхтэй.

Олон нийт ба бүс нутаг

Орано групп нь уур амьсгал, эрүүл мэнд, байгалийн нөөцийг хадгалан хамгаалах замаар бүс нутаг болон нийгмийн хөгжилд өөрийн мэдлэг, туршлагаа ашиглан урт хугацааны туршид үнэтэй хувь нэмэр оруулж байгаагаараа бахархдаг.

Орано групп нь өөрийн үйл ажиллагаанаас хүн ам ба хүрээлэн буй орчинд үзүүлж болох эрсдэл болон нөлөөллийг хянахад чиглэсэн хөтөлбөрүүдээрээ дамжуулан үйлдвэрлэлийн болон уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй бүс нутаг дахь хүрээлэн буй орчинд группийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулах болон биологийн олон янз байдлыг хадгалах чиглэлээр орон нутгийг дэмжиж ажилладаг. Түүнчлэн бүс нутгийн эдийн засгийн өсөлт, ур чадвар болон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.

Орано групп нь олон нийтийн хэлэлцүүлэгт ил тод, нээлттэй оролцох зарчмыг баримталдаг. Бид стратегийн болон технологийн шийдлүүдээ үнэн шударгаар тайлбарлан таниулж, өөрийн үйл ажиллагаа хийгээд түүнээс үүдэж болзошгүй үр дагаврын талаар шийдвэр гаргагчид болон иргэдэд мэдээлэл өгч ажиллахад анхаардаг. Төслийн үйл ажиллагааны хүрээнд олон нийтийг тогтмол мэдээллээр хангаж тэдний саналыг анхааралтай сонсохын тулд албан ёсны хороодууд болон төрөл бүрийн харилцаа холбооны сувгуудыг ашиглан оролцогч талуудтай харилцан ярилцаж хэлэлцдэг байхад анхаардаг. Энэ хүрээнд бид мэдээлэл, харилцаа холбооны сувгуудыг ашиглахдаа ёс зүйн зарчмуудаа баримталдаг.

Орано групп нь мэргэжлийн сургалтуудыг хөгжүүлэх болон залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар цөмийн материалыг хувиргах болон хянах талаар нарийн мэргэжлийн мэдлэг туршлага, ур чадварыг хөгжүүлэхэд хувь нэмэрээ оруулахыг эрмэлздэг. Эцэст нь Орано групп нь бидний ирээдүй хойч үед тулгарч буй даян дэлхийн асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулахыг эрмэлздэг. Үүнд:

- Өрсөлдөх чадвартай, нүүрс төрөгч бага ялгаруулдаг эрчим хүч үйлдвэрлэж уур амьсгалын өөрчлөлт, эрчим хүчний хомсдолтой тэмцэх;
- Түүхий эдийг дахин боловсруулж байгалийн нөөцийг хэмнэх;
- Нийтийн эрүүл мэндийг хамгаалах.

4 Хүн ам, хүрээлэн буй орчин болон бидний нөөц баялагийг хамгаалахад чиглэдэг манай бодлого

Хувь хүн болон хүний эрхийг хүндэтгэх

Орано групп нь хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөр эрхлэлтийн аливаа хэлбэрийг устгах, сайн дураар эвлэлдэн нэгдэх, хувь хүний эрх болон хамтын гэрээ, хэлэлцээр хийх эрхийг хүндэтгэж, хүний нэр төр, эрхэм чанарыг дээдлэх, ялангуяа аливаа хэлбэрийн дарамт шахалт, хүний эрхийн зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн төрөл бүрийн арга хэмжээг хэрэгжүүлж ажилладаг.



БОЛОХГҮЙ:

- Хамтран ажиллагч эсвэл Орано группийн оролцогч талуудтай харьцахдаа биеэ зохисгүй авч явах эсвэл бусдыг гомдоох үг, хэллэг ашиглах
- Хамтран ажиллагчаа харагдах байдал, шашин шүтлэг, итгэл үнэмшил, үзэл бодол эсвэл настай нь холбоотойгоор шүүмжлэх



БОЛНО:

- Үлгэр дууриалал үзүүлж цаг үргэлж хамтран ажиллагчиддаа хүндэтгэлтэй хандах,
- Ханган нийлүүлэлтийн сүлжээнд хүний эрхийн зөрчил гарахгүй байхад анхаарах

Аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, хүрээлэн буй орчин ба эрүүл мэндийг хамгаалах

Орано групп нь төслийн талбай дахь үйл ажиллагаагаа аюулгүй байдал, хүрээлэн буй орчин, хөдөлмөрийн эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа, хүн болон барилга байгууламжийг хамгаалах чиглэлээр хүчин төгөлдөр хууль журам болон группийн бодлогыг мөрдөж ажилладаг.

Орано группийн ажилтнууд хаана байхаас үл хамааран дараах зан төлөв ба үйлдлүүдийг хэвшүүлж ажилладаг:

- Мэдлэг чадвар, нөөц боломж болон туршлагаа хамгийн сайнаар ашиглаж цөмийн ба хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд болон хүрээлэн буй орчныг хамгаалахад чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлдэг.
- ЭМХААБО-ны (Эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа ба байгаль орчин) зааварчилгааг үлгэр жишээч байдлаар хэрэгжүүлж, гүйцэтгэх гэж буй ажил эсвэл анзаарсан асуудлынхаа талаар нягтгалж, асуудал дэвшүүлдэг.
- Төслийн барилга, байгууламж болон цөмийн материал, түүний тээвэрлэлтийг чиглэсэн аливаа аюул заналхийлэл болон түрэмгий үйлдлээс хүн ба хүрээлэн буй орчинг хамгаалдаг.
- Өөртөө болон бусдад учирч болзошгүй эрсдэл эсвэл ЭМХААБО-ны аливаа зөрчлийг мэдээлдэг.

Орано групп нь үндэсний ба олон улсын хууль журмын шаардлагад нийцсэн үндсэн дүрэм, стандартуудыг хэрэгжүүлдэг. Өдөр тутмын үлгэр жишээч зан төлөвт тулгуурлан урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр нөлөөг хадгалах, байнгын сонор сэрэмжийг нэмэгдүүлэх, хэвийн бус буюу эрсдэлт нөхцөл байдлыг цаг алдалгүй мэдээлдэг.



БОЛОХГҮЙ:

- ЭМХААБО-ны эрсдэлийг үл тоомсорлох
- Энэ талаар суралцах, сургалтанд хамрагдахаас татгалзах



БОЛНО:

- ЭМХААБО-ны зааварчилгааг чанд мөрдөх, гүйцэтгэх гэж буй ажил эсвэл анзаарсан асуудлынхаа талаар үргэлж нягтлах, асуудал дэвшүүлэх
- Өөртөө болон бусдад учирч болзошгүй эрсдэл эсвэл ЭМХААБО-ны аливаа зөрчлийг мэдээлэх

Чанар

Орано групп нь өндөр чанартай бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангадаг. Групп нь үйлчлүүлэгчдийнхээ хүлээлтэнд нийцсэн чанартай бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэхийн тулд холбогдох хууль журам ба гэрээний шаардлагыг бүрэн хангаж, олон улсын шилдэг туршлагыг хэрэгжүүлж ажиллахыг эрмэлздэг.

Групп нь өөрөө эсвэл түүний ханган нийлүүлэгчид болон гэрээлэгчид үйлдсэн эсэхээс үл хамааран бүх төрлийн чанарын залилан, доголдолтой хатуу тэмцдэг.



БОЛОХГҮЙ:

- Үр дүнд хүрэхийн тулд зөрчилд хүргэж болзошгүй дарамтанд бууж өгөх
- Чанарын залилан эсвэл доголдолыг нуун дарагдуулах эсвэл мэдээлэхгүй байх



БОЛНО:

- Группийн зан төлөвийн дүрэм болон чанарын бодлогын дагуу арга хэмжээ авах
- Сонор сэрэмжтэй байх, аливаа доголдолыг мэдээлэх

Нэр хүнд ба дүр төрх

Орано группийн нэр хүнд бол бидний гол хөрөнгө юм.

Ажилтан нэг бүр хэн нэгний эсвэл группийн нэр төрийг гутаасан, дайрч доромжилсон, үл хүндэтгэсэн гэж үзэж болохуйц үйлдэл эсвэл үг хэллэгийг ялангуяа олон нийтийн дунд ашиглахаас зайлсхийнэ.

Гадаад болон дотоод нийгмийн сүлжээг хувийн хэрэгцээнд ч бай анхаарал болгоомжтой ашиглана.

Үндэсний болон олон улсын харилцаанд оршин байгаа газраа хүндэтгэх гэдэг нь хамтран ажиллагдааа үл тоомсорлох, бүдүүлгээр эсвэл ёс зүйгүй харьцахыг хориглох тухай ойлголт юм.



БОЛОХГҮЙ:

- Орано группийн нэр хүнд ба дүр төрхөд халдах зорилгоор доромжлол, ялгаварлан гадуурхалтын шинжтэй зүйлс нийтлэх, мэдэгдэл хийх ба үйлдэл хийх



БОЛНО:

- Сэтгүүлч болон бусад хэвлэл мэдээллийн байгууллагаас хүсэлт ирүүлсэн бол Группийн болон тухайн салбар байгууллагын Олон нийттэй харилцах хэлтэстэй холбогдох

Биет бус хөрөнгө

Ажилтнууд "Ораногийн нууц мэдээлэл" эсвэл "Хязгаарлагдмал хүрээнд тараана" хэмээн тэмдэглэсэн эсэхээс үл хамааран группийн стратегийн болон нууц мэдээлэлд халдах, хулгайд алдах, гэмтээх, буруугаар ашиглах, задруулах, хуулбарлах, хуурамчаар үйлдэх, ажлын бус хэрэгцээнд, хууль бусаар эсвэл зохисгүйгээр интернет, дотоод болон нийгмийн сүлжээнд ашиглах явдлаас хамгаална.

Энэ нь техник, менежмент, хувь хүн, биет ба биет бус бараа бүтээгдэхүүн болон цөмийн материалын хамгаалалттай холбоотой мэдээллийг хамгаалах зорилготой.

Үүнд үйлчлүүлэгч, боломжит үйлчлүүлэгч болон ханган нийлүүлэгчдийн файлууд, нууц үг, баримт бичиг болон зураг төсөл, арга аргачлалууд, ноу-хау, худалдааны нууц, оюуны ба үйлдвэрлэлийн өмч, таамаглал, гэрээ хэлэлцээр, үйлдвэрлэлийн зардал ба борлуулалтын үнэ, стратеги болон бизнесийн төлөвлөгөөнүүд, судалгаа, хөгжүүлэлт болон инновацитай холбоотой мэдээлэл, санхүүгийн болон үйлдвэрлэлийн мэдээлэл, мэргэжилтнүүдийн нэр болон дэлгэрэнгүй мэдээлэл, түүнчлэн аливаа цуглуулсан болон боловсруулсан хувь хүний мэдээлэл зэрэг орно.



БОЛОХГҮЙ:

- Компьютероо түгжихгүй эсвэл эзэнгүй үлдээх
- Илгээгч нь тодорхойгүй эсвэл сэжигтэй имэйлд хариулах



БОЛНО:

- Ашигласан мэдээллийн эх үүсвэрийг нягтлах, сэжигтэй тохиолдлыг мэдэгдэх
- Мэдээллийг зохистой удирдах, сонор сэрэмжтэй байх

Хувь хүний мэдээллийг хамгаалах

Хувь хүний мэдээллийн хамгаалалт гэдэг нь аливаа бие хүний цахим болон цаасан хэлбэрийн мэдээлэл ашиглалтыг хэлнэ.

Орано групп нь хувь хүний мэдээллийг хамгаалж, үйл ажиллагаа явуулж буй улс орнуудад мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм журмын (Европын холбооны Ерөнхий мэдээлэл хамгаалах журам болон Франц улсын Мэдээллийн технологи болон хувь хүний чөлөөт байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга г.мэт) хэрэгжилтийг бүрэн хангахын тулд хуулийн нийцлийн системийг нэвтрүүлсэн.



БОЛОХГҮЙ:

- Хувь хүний мэдээлэлд нэвтрэх эрхгүй этгээдийг нэвтрүүлэх
- Хэт их мэдээлэл цуглуулах эсвэл мэдээллийг хууль бус зорилгоор ашиглах



БОЛНО:

- Хувь хүний зөвхөн шаардлагатай мэдээллийг тодорхой зорилгоор цуглуулах
- Хувь хүний мэдээллийг ашиглахаасаа өмнө Өгөгдлийн хамгаалалт хариуцсан ажилтанд мэдэгдэж Өгөгдлийн хамгаалалтын санд бүртгэх, шинжлэх

5 Бидний ажил хэргийн зан төлөвийн дүрэм

Бидний ажил хэргийн зан төлөвийн дүрэм нь болзошгүй эрсдлийг илрүүлэх, тохиромжтой шийдлүүдийг санал болгох замаар нөхцөл байдалд тохирсон хариу үйлдэл үзүүлэхэд нь ажилтнуудад тусална. Илүү дэлгэрэнгүй журмуудтай дотоод сүлжээнээс танилцах боломжтой бөгөөд шаардлагатай бол Хуулийн нийцлийн хэлтэс болон холбогдох мэргэжилтнүүдэд хандсанаар тусламж авах боломжтой.

Энэхүү дүрэмд одоо эсвэл ирээдүйн ажил хэргийн харилцааны хүрээнд Орано группийн ажилтан, удирдлагууд болон бусад төлөөлөгчдийн зүгээс төр, захиргааны байгууллагууд, үйлчлүүлэгчид, ханган нийлүүлэгчид болон түншүүдтэй харилцахдаа баримтлах зан төлөвүүдийг тодорхойлсон.

Авлига ба зүй бус нөлөөлөл

Группийн хэмжээнд авлига, зүй бус нөлөөллөөс урьдчилан сэргийлэх асуудалд онцгой анхаардаг. Эдгээр дүрмүүд нь Орано группийн дэлхий даяарх ажилтан, удирдлагуудаас гадна үйлдвэрлэл болон бизнесийн түншүүдийг хамардаг бөгөөд бидний үнэнч шударга, үлгэр жишээч зан төлөвт харшлах үйлдлүүдээс хамтдаа сэргийлдэг.

Орано групп нь үйл ажиллагаагаа явуулж буй дэлхий даяарх улс орнуудад идэвхтэй ба идэвхгүй, төрийн болон хувийн хэвшлийг хамарсан авлига, зүй бус нөлөөллийн аливаа хэлбэрийг үл тэвчих бодлого баримталдаг.

Орано групп нь Франц улсын, олон улсын эсвэл гадаад улсын төр, захиргааны байгууллагууд эсвэл засгийн газар, тэдгээрийн ажилтнуудад зүй бусаар нөлөөлөх аливаа оролдлогыг эрс хориглодог.

→ Орано групп нь шууд ба шууд бусаар улс төрийн албан тушаалтан эсвэл төрийн ба хувийн хэвшлийн төлөөлөгчдөд зөвшөөрөгдсөн үнийн дүнгээс хэтэрсэн төлбөр, үйлчилгээ, бэлэг сэлт болон аливаа хэлбэрийн давуу тал олгох, санал болгох, амлах, эсвэл шаардах эсвэл хууль бус аргаар гэрээ, арилжааны давуу байдлыг олж авахыг өөртөө болон бусдад шууд хориглодог бөгөөд эдгээр үйлдлүүд нь идэвхтэй авлигийн хэлбэрт тооцогдоно.

→ Үүний нэгэн адил Орано групп нь шууд ба шууд бусаар төр, захиргааны байгууллагуудаас аливаа давуу тал, албан тушаал, гэрээ хэлэлцээр эсвэл бусад таатай шийдвэр гаргуулахын тулд өөрийн бодит эсвэл боломжит нөлөөллийг ашиглаж аливаа санал, амлалт, хандив, бэлэг сэлт, урашмуулал эсвэл бусад зохисгүй давуу талыг өөрийн эсвэл бусдын нэрийн өмнөөс олгох хүсэлтийг хүлээн авахыг өөртөө болон бусдад хориглодог бөгөөд эдгээр үйлдлүүд нь зүй бус нөлөөллийн хэлбэрт тооцогдоно.

→ Эцэст нь Орано групп нь ажилтнууд болон түншүүддээ гэрээ хэлэлцээр, албан тушаал эсвэл бусад таатай шийдвэр гаргуулахын тулд хандив, бэлэг сэлт эсвэл аливаа зохисгүй давуу тал олгох хүсэлтийг хүлээн авах эсвэл шаардахыг өөртөө, өөрийн ажилтнууд болон түншүүддээ хориглодог бөгөөд эдгээр үйлдлүүд нь идэвхгүй авлигийн хэлбэрт тооцогдоно.

Ажилтнууд өөрсдийгөө гуравдагч этгээдийн өмнө ямар нэг үүрэг хүлээх эсвэл хоёрдмол утга бүхий тодорхойгүй нөхцөл байдалд оруулахаас сэргийлнэ.

Орано группийн хуулийн нийцлийн хэлтэсээс авлига, зүй бус нөлөөллөөс урьдчилан сэргийлэх цогц хөтөлбөрийг боловсруулсан. Тус хөтөлбөртэй группийн дотоод сүлжээнээс танилцах боломжтой бөгөөд нийт ажилтнууд дагаж мөрдөнө.



БОЛОХГҮЙ:

- Гэрээ хэлэлцээр байгуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор давуу тал олгох эсвэл хүсэлтэнд хариулах
- Төр, захиргааны байгууллагуудын албан тушаалтнуудад зохисгүй давуу тал санал болгох замаар төр, захиргааны шийдвэрт нөлөөлөх



БОЛНО:

- Авлига, зүй бус нөлөөллийн бодит үйлдлүүдийг илрүүлсэн тохиолдолд үл тэвчих бодлогыг хэрэгжүүлэх
- Эрсдэлтэй нөхцөл байдлыг өөрийн шууд удирдлага болон Хуулийн нийцлийн хэлтэст мэдэгдэх

Мөнгө угаах

Орано групп нь шууд ба шууд бус хэлбэрээр бүх төрлийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийг хориглодог. Орано групп нь энэ талаар холбогдох хууль журмыг (ялангуяа Европын Холбооны 3, 4, 5 дугаар удирдамж г.мэт) дагаж мөрддөг.

Энэ чиглэлээр групп нь бизнес түншүүдийнхээ эрсдэлийн зэргийг нь харгалзан зохих хяналт шалгалтыг хийж, санхүүгийн урсгалд хяналт тавьж ажилладаг.



БОЛОХГҮЙ:

- Хүлээн авсан гүйлгээний эх үүсвэр, гүйцэтгэсэн төлбөрийн хүлээн авагчийг нуун дарагдуулах



БОЛНО:

- Бизнес түншүүд, тэдний эцсийн ашиг хүртэгч эздийн талаар мэдээлэлтэй байх, эрсдэлтэй нөхцөл байдлыг мэдээлэх

Ажил хөнгөвчилсний төлбөр

Ажил хөнгөвчилсний төлбөр гэдэг нь төлбөр төлөгчөөс ямар нэг журмын шаардлага эсвэл захиргааны ажилагааг (гаалийн хяналт, зөвшөөрөл, виз, хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох г.мэт) хөнгөвчлөх эсвэл зохицуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ихэнхдээ төр, захиргааны байгууллагын эсвэл хувийн хэвшлийн албан тушаалтнуудаас санал болгосон эсвэл хүссэн бага дүнтэй албан бус төлбөр юм.

Группийн үйл ажиллагаа явуулдаг бүх улс орнууд, түүний дотор тухайн улсын хууль журмаар хориглосон эсэхээс үл хамааран ажил хөнгөвчилсний төлбөрийг хориглодог.

Олон улс орнууд, түүний дотор Франц улсад ажил хөнгөвчилсний төлбөр нь түүний давтамж, хэмжээг үл харгалзан хууль бусад тооцогддог бөгөөд авлига гэж үздэг.

Орано групп нь тухайлбал тамхи, согтууруулах ундаа, аливаа эд зүйлс зэрэг бага дүнтэй жижиг бэлэг сэлт, дурсгалыг дээр дурдсан зорилгоор өгснийг ажил хөнгөвчилсний төлбөр гэж үздэг.



БОЛОХГҮЙ:

- Зохисгүй хүсэлтийг хүлээн авах (бие махбодийн бүрэн бүтэн, аюулгүй байдал эрсдэлд орсноос бусад тохиолдолд)



БОЛНО:

- Хүсэлтээс эрс татгалзах, албан хүчээр төлбөр төлөх тохиолдолд өөрийн шууд удирдлага болон Хуулийн нийцлийн мэргэжилтэнд мэдэгдэх

Бэлэг дурсгал ба урилга

Орано групп нь бага дүнтэй бэлэг дурсгал, урилгыг тохиолдлоор хүлээж авах эсвэл өгөх нь заримдаа бизнесийн харилцааг амжилттай явуулахад хуул ёсны дагуу хувь нэмэр оруулдаг болохыг хүлээн зөвшөөрдөг.

Энэ талаар ажилтнууд хянуур болгоомжтой байж, хариуцлагатай хандах ёстой. Ямар нэг эргэлзээ үүсвэл санал болгосон бэлэг дурсгал, урилгаас татгалзах, эсвэл өөрийн шууд удирдлага болон Хуулийн нийцлийн хэлтсэст мэдэгдэж, зөвшөөрөл хүснэ. Бэлэг дурсгал, урилгыг баримтжуулж, байгууллагын санхүүгийн бүртгэлд оруулна.

Ажилтан зарим тохиолдолд орон нутгийн зан заншлаас шалтгаалан зөвшөөрөгдөх үнийн дүнгээс хэтэрсэн үнэтэй бэлэг дурсгал, урилгыг хүлээн авах эсвэл санал болгох нөхцөл байдалд байгаа бол группийн холбогдох журмыг баримтлан энэ талаар өөрийн шууд удирдлагад урьдчилан мэдэгдэж, бичгээр зөвшөөрөл авч, холбогдох бүртгэлд оруулна.

Зохисгүй эсвэл бизнесийн харилцаанд хамааралгүй байршилд бэлэн мөнгөний төлбөр эсвэл эрхийн бичиг гэх мэтчилэн ижил төрлийн эд зүйлс, хувийн үйлчилгээ, зээл, урилга, бэлэг дурсгал зэргийг хүлээн авах эсвэл өгөхийг хатуу хориглоно.

Үйлчлүүлэгчдэд зориулан зохион байгуулж буй аливаа арга хэмжээ нь хууль ёсны бизнесийн зорилготой байх ёстой бөгөөд зохих түвшинд бүх нөхцөл ба болзлын хувьд урьдчилан батлагдсан байх ёстой.



БОЛОХГҮЙ:

- Бэлэг дурсгал, урилгыг хүлээн авах нь таны үнэнч шударга байдалд эргэлзээ төрүүлэх
- Шууд удирдлагатайгаа хангалттай ил тод байх байхгүй байх



БОЛНО:

- Бизнесийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай эсвэл нөлөөлсөн гэж үзэж болохуйц бэлэг дурсгал, урилгаас эелдэгээр татгалзах
- Ээдрээтэй нөхцөл байдлыг Хуулийн нийцлийн хэлтэст мэдэгдэх

Ашиг сонирхлын зөрчил

Ашиг сонирхлын зөрчил нь нийгэмд түгээмэл тохиолддог бөгөөд хүн бүр группийн ашиг сонирхолтой (мэргэжлийн, гэр бүл, улс төрийн, ассоциатив, буяны, үйлдвэрчний эвлэл, шашин, соёл, спорт, философийн г.мэт) зөрчилдөж болохуйц нөхцөл байдалд орох боломжтой.

Орано групп нь эдгээр ашиг сонирхлын зөрчилд ихээхэн анхаарал хандуулдаг. Хэрэв тэдгээрийг нээлттэй, ил тод тайлагнаж, зохих ёсоор арга хэмжээ авахгүй бол Группийн бизнесийн үйл ажиллагаа, нэр хүндэд томоохон хор хөнөөл учруулж болзошгүй юм. Залилан, авлига, үл нийцэл ба зөрчил, зохисгүй бизнесийн гэрээ хэлэлцээр, мэдээлэл алдалт, дотоод хяналтын алдаа, давуу тал олголт, группийн нөөцийн зохисгүй ашиглалт, хууль бус хувьцааны арилжаа зэрэг нь ашиг сонирхлын зөрчилд багтах ба үүгээр хязгаарлагдахгүй.

Ажилтан бүр ажил үүргээ гүйцэтгэж байхдаа хувийн эсвэл ойр дотны хэн нэгний ашиг сонирхол нь Орано группийн ашиг сонирхолтой зөрчилдөх нөхцөл байдалд орох боломжтой.

Удирдлагад мэдэгдсэн ашиг сонирхлын зөрчлийг хоёр шатны удирдлагын түвшинд асуудал бүрт дүн шинжигээ хийж, холбогдох хууль журмын дагуу шийдвэрлэдэг.



БОЛОХГҮЙ:

- Ашиг сонирхлын зөрчлийг нуун дарагдуулах



БОЛНО:

- Сэжигтэй эсвэл батлагдсан ашиг сонирхлын зөрчлийг өөрийн шууд удирдлагад ил тодоор, шуурхай мэдээлсний үр дүнд шийдвэрлэх боломжтой болох

Өрсөлдөөний тухай хууль

Орано групп, түүний ажилтнууд аливаа бизнесийн гэрээ хэлэлцээр, сонгон шалгаруулалтын урилга зэргээр группийн үйл ажиллагааны хүрээнд шууд ба шууд бусаар чөлөөт өрсөлдөөнийг хязгаарлах явдлаас сэргийлдэг. Групп, түүний ажилтнууд хууль бус гэрээр хэлэлцээр хийх, эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, группийн өрсөлдөгчид эсвэл үйлчлүүлэгчдийн өмнө шударга бус байдал гаргахаас зайлсхийдэг.

Орано групп, түүний ажилтнууд үйл ажиллагаа явуулж буй улс орнуудад мөрдөж буй өрсөлдөөний талаар хууль журмыг чандлан мөрддөг.

Гуравдагч талууд, ялангуяа Орано группийн өрсөлдөгчдийн талаархи аливаа мэдээллийг зөвхөн холбогдох хууль журмын хүрээнд цуглуулж, ашиглах ёстой.



БОЛОХГҮЙ:

- Чөлөөт өрсөлдөөнийг зөрчих, ялангуяа үнэ эсвэл зах зээлийг хуваан авахаар үгсэн тохиролцох
- Арилжааны чухал мэдээллийг өрсөлдөгчтэйгээ хуваалцах



БОЛНО:

- Бизнесийн харилцаанд үргэлж үнэнч шударгаар хандах
- Зах зээлийн зохицуулагч байгууллагуудтай тогтмол хамтран ажиллах

Экспортын хяналт ба олон улсын хориг арга хэмжээ

Орано групп нь аливаа хоёрдмол хэрэглээний бараа бүтээгдэхүүн (иргэний болон дайны зорилгоор ашиглах боломжтой бараа бүтээгдэхүүн), технологи, өгөгдөл, үйлчилгээг экспортлох болон дамжуулахдаа цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх тухай үндэсний, европын болон олон улсын холбогдох хууль журам, ОУАЭА (Олон улсын атомын энергийн агентлаг)-ийн баталгаа ба экспортын хяналтыг чанд мөрдөж ажилладаг. Эдгээрээс өөр нөхцөл болзлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулахаас татгалздаг.

Групп нь олон улсын хориг арга хэмжээг зохицуулахтай холбоотой хууль журмыг дагаж мөрдөх үүрэг хүлээдэг.



БОЛОХГҮЙ:

- Тусгай зөвшөөрөлгүйгээр хоёрдмол хэрэглээний бараа бүтээгдэхүүн экспортлох
- Улс орнуудын тавьсан олон улсын хориг арга хэмжээний цар хүрээг дутуу үнэлэх



БОЛНО:

- Экспортын хяналт хариуцсан ажилтантай зөвлөлдөх
- Төслийн үе шат бүрт авах арга хэмжээний талаар өөрөөсөө асуух

Гуравдагч талуудын харилцаа

Группийн нэр хүндийг хадгалахын тулд бидний шударга байдал, үнэт зүйлийг эрхэмлэх бодлогыг хүндэтгэдэг бизнесийн түншүүдтэй хамтран ажиллах нь чухал юм. Хамтрагч түншүүдийн аль нэгний ёс зүйгүй байдал нь холбогдох журмыг зөрчиж, бидний нэр хүндэд ноцтой хохирол учруулах боломжтой.

Түнш гэдэгт групптэй хамтран ажиллаж, бизнесийн харилцаа тогтоосон аливаа талууд, компани эсвэл хувь хүмүүс (үйлчлүүлэгч, ханган нийлүүлэгч ба гэрээлэгч, зөвлөх, үйлчилгээ үзүүлэгч, борлуулалтын зууч, зуучлагч, лоббист, хамтарсан хөрөнгө оруулагч, ивээн тэтгэлэгийн эцсийн үр шим хүртэгч, зорилтот бүлэг болон төслийн шилжилтийн үеийн хамтрагчид г.мэт) багтана.

Тодорхойлсон эрсдлийн түвшингээс хамааруулан Орано групптэй хамтран ажиллаж буй гуравдагч талуудын найдвартай байдалд тусгайлан шалгалт хийдэг.

Группийн нийт салбар байгууллага болон ажилтнууд ямар ч тохиолдолд ашигласан мөнгөнийн хэмжээг харгалзахгүйгээр түүнийгээ нотлох (ялангуяа үйлчлүүлсэн баримт, эцсийн үр шиг хүртэгчийн талаар тодорхой мэдээлэл г.мэт) боломжтой байх ёстой. Төлбөр төлөгч эсвэл эцсийн үр шим хүртэгчийг нуун дарагдуулахад чиглэсэн аливаа төлбөрийн арга хэрэгслийг хориглоно.

Зуучлагчдын тухайд групп нь бизнес түншүүдтэйгээ шууд харилцах журамтай. Журмаас гадуурх тохиолдолд группийн хуулийн нийцлийн хороо дэлгэрэнгүй хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэнэ.



БОЛОХГҮЙ:

- Хуулийн нийцлийг шалгахгүйгээр түнштэй бизнесийн харилцаанд орох



БОЛНО:

- Группийн журмын дагуу гуравдагч этгээдээ үүдэж болох хуулийн нийцлийн эрсдлийг шинжлэх
- Хуулийн нийцлийн хэлтсийн мэргэжилтэнтэй бүх асуудлаар холбогдох

Сонирхлын төлөөлөл ба улс төрийн санхүүжилт

Лоббидох гэж нэрлэдэг эрх баригчдад үзүүлэх сонирхлын төлөөллийн асуудал нь улс орнуудаас (Франц улсын Сапин II хууль г.мэт) гадна олон улсын байгууллагуудын хууль тогтоомж, дүрэм журмаар зохицуулагддаг. Орано групп нь эдгээр хууль журмыг дагаж мөрддөг ба тайлагнах үүргийг ч мөн хэрэгжүүлдэг.

Зүй бус давуу эрх санал болгосны хариуд төр, захиргааны шийдвэрт шууд ба шууд бусаар нөлөөлөхөд чиглэсэн аливаа сонирхлын төлөөллийн үйлдлийг хориглодог.

Улс төрийг санхүүжүүлэх тухайд группийн нэг ч салбар байгууллага аливаа улс төрийн нам, албан тушаалтан, нэр дэвшигчид хандив тусламж, аливаа үйлчилгээ үзүүлдэггүй. Гэхдээ ийм төрлийн хандив тусламж үзүүлэх явдлыг хуулиар хориглодоггүй ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын хувьд тухайн улсын хууль журмын хүрээнд сонгуулийн кампанит ажилд зориулан хандив тусламж үзүүлж болно. Ийм төрлийн хандив тусламж нь тухайн салбар байгууллагыг хариуцсан удирдах албан тушаалтаны бичгээр олгосон зөвшөөрөлд үндэслэх ёстой ба тэрбээр хандив тусламжийг зохистой доод хэмжээнд барих үүрэг хүлээнэ.



БОЛОХГҮЙ:

- Төр, захиргааны албан тушаалтантай холбогдохдоо Группийн эсвэл өөрийн салбар байгууллагын Төрийн байгууллагын асуудал эрхэлсэн хэлтэст мэдээлэхгүй эсвэл зөвлөлдөхгүй байх



БОЛНО:

- Лоббидох үйл ажиллагаатай холбоотой ямар ч төлбөр урамшууллын хүсэлтээс татгалзах

Ивээн тэтгэлэг, хандив болон хүмүүнлэгийн үйл ажиллагаа

Хандив, ивээн тэтгэлэг болон хүмүүнлэгийн үйл ажиллагааны хүрээнд түншлэл байгуулах стратегийг үйл ажиллагааны хөтөлбөрийн хамт Орано группийн хэмжээнд тодорхойлдог.

Бид үйл ажиллагаандаа баримтлах үндсэн зарчмуудаа «Бидний Үнэт Зүйлс»-дээ тодорхойлсон бөгөөд захиргааны болон арилжааны шинжтэй төлбөр урамшууллыг олгохгүй байх зарчимтай.

Бид зөвхөн түншийн хэмжээнд ажилладаг бөгөөд төслийг удирдах эсвэл гүйцэтгэх үүргийг хүлээдэггүй. Хууль, эрх зүйн болон захиргааны шаардлагуудыг хангаж, шаардлагатай бүх зөвшөөрөл, баталгааг бүрдүүлсний үндсэн дээр төсөл санаачлан хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж оролцдог.

Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд үзүүлсэн ивээн тэтгэлэг нь улсын эсвэл орон нутгийн төр, захиргааны байгууллага эсвэл хувь хүнд олгосон хандив тусламж болон бэлэн мөнгөний төлбөрөөс ангид юм.



БОЛОХГҮЙ:

- Группийн бодлогоор тодорхойлсоноос бусад холбоод болон арга хэмжээг ивээн тэтгэх



БОЛНО:

- Группийн түншлэлийн бодлогын хүрээнд холбоо эсвэл төсөл санаачлагчдад дэмжлэг үзүүлэхдээ гуравдагч талын нийцлийн хяналтыг хийж гүйцэтгэсний дараа Олон нийттэй харилцах хэлтэсийн зөвшөөрлийг авч Орано групп болон үр шим хүртэгч нарын хоорондахь хамтын ажиллагааг албажуулах

Инсайдер арилжаа (мэдээлэлд ойр хүмүүс компанийн хувьцааг худалдан авах, арилжаалах)

Группийн удирдлага, ажилтнууд нууцлалын журмыг чанд сахиж ойр дотны хүмүүстэйгээ мэдээлэл хуваалцахдаа ч анхаарал болгоомжтой хандах үүрэгтэй. Дээрхээс үүдэж болзошгүй инсайдер арилжааны талаар мэдээлэлтэй байж нууц мэдээлэлтэй харьцахдаа одоо үйлчилж буй группийн журмыг дагаж мөрдөнө.

Компанийн удирдлага, аливаа нууц мэдээлэл олж авсан ажилтнууд нь зөвхөн хэлэлцээрээр баталгаажиж, группээс гаргасан үнэт цаас, түүний дотор хууль журмын хүрээнд Орано группийн гаргасан өрийн үнэт цаас, эсвэл үнэт цаасны биржид бүртгэлтэй болон бүртгэлгүй үнэт цаасыг группийн нууц мэдээллийг удирдлах журмын дагуу шууд ба шууд бус хэлбэрээр авах буюу шилжүүлэх үүрэг хүлээнэ. Түүнчлэн энэ талаар компанийн зохицуулагч байгууллагуудад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

Ажилтнууд ажил үүргийнхээ хүрээнд олж авсан нууц мэдээллийг группийн түнш, ханган нийлүүлэгч, үйлчлүүлэгч эсвэл бусад хамтрагчдаас гаргасан үнэт цаасыг худалдан авах, шилжүүлэх зорилгоор ашиглахыг хориглоно.



БОЛОХГҮЙ:

- Хууль бус орлого олоход хүргэж болзошгүй нууц мэдээллийг задруулах буюу ашиглах



БОЛНО:

- Ялангуяа үр дүн нь олон нийтэд мэдэгдэхээс өмнө эмзэг, нууц мэдээлэлтэй анхаарал болгоомжтой харьцах

Залилан

Орано группийн нэр хүнд төдийгүй бүтээмжид мэдэгдэхүйц нөлөөлөх магадлалтай тул бүх төрлийн залилангаас урьдчилан сэргийлдэг.

Залилан нь хууль бус давуу байдал олж авах, хууль ёсны үүрэг хариуцлага эсвэл байгууллагын дүрэм журмаас зайлсхийж хүнийг санаатайгаар хууран мэхлэх явдал юм. Залилан мэхлэх сэдэл нь материаллаг (хөрөнгө, мөнгөн орлогыг завших г.мэт) эсвэл ёс суртахууны (нэр хүндээ хүлээн зөвшөөрүүлэх эсвэл хадгалах хүсэл эрмэлзэл г.мэт) байж болно. Энэ нь идвэхтэй эсвэл идэвхгүй байдалтай байх боломжтой ба байгууллага дотроос эсвэл гаднаас үүсч болно.

Групп нь эдгээр эрсдлийг бууруулахад чиглэсэн тодорхой дүрэм журмыг хэрэгжүүлдэг ба дотоод хяналтын системийн тусламжтайгаар залилан мэхлэх явдалтай тэмцдэг.



БОЛОХГҮЙ:

- Нотлох баримт болон шат дараалсан зөвшөөрлийн бүрдлийг шалгахгүйгээр төлбөр хийх
- Ажлаа түргэн явуулахын тулд нягталж шалгахгүй байх



БОЛНО:

- Сэжигтэй эсвэл ердийн бус хүсэлтийг нягтлах
- Эргэлзээтэй тохиолдолд тусламж хүсэх

6 Шүгэл үлээх СИСТЕМ

Орано групп нь ёс зүйн үүрэг амлалтынхаа хүрээнд ёс зүйн аливаа зөрчлийг мэдээлэх, цуглуулах, боловсруулах зорилгоор шүгэл үлээлгэх системийг хэрэгжүүлдэг.

Хууль журмаар хүлээсэн үүргээ илт үл тоомсорлож биелүүлээгүй, эсхүл энэхүү ёс зүйн дүрмийг дагаж мөрдөөгүй тохиолдлыг нэн даруй мэдэгдэх нь бидни зуршил төдийгүй үүрэг хариуцлага юм. Хэн ч өөрийн шууд удирдлагадаа тэр дор нь мэдээлэх боломжтой ба мэдээллийн урсгалд ямар нэг саад эсвэл тодорхой шат зэрэглэл гэж байхгүй.

Ажилтанд ёс зүйн талаар аливаа асуулт эсвэл мэдээлэх зөрчил байвал өөрийн шууд эсвэл шууд бус удирдлага, эсвэл бусад удирдлагатай энэ талаар ярилцах, аль эсвэл өөрийн байгууллага эсвэл нэгжийн хуулийн нийцлийн мэргэжилтэн эсвэл группийн хуулийн нийцлийн захиралтай холбогдоно.

Хэн нэгэн (группийн ажилтан эсвэл ханган нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч, түнш эсвэл захиалагч) Орано группийн ёс зүй ба ажил хэргийн зан төлөвийн дүрмийг зөрчсөн талаар мэдээлэл байгаа бол өөрийн удирдлага, эсвэл шүгэл үлээх талбараар (группийн дотоод сүлжээ болон гадны порталаас нэвтрэх боломжтой) дамжуулан мэдээлэх боломжтой. Мэдээллийн зохистой байдлыг шалгаж үзсэний дараа мэдээллийг тодруулах дараагийн шатны шалгалтыг хийх ба ингэснээр залруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх боломжтой болно.

Хуульд заасанчлан Орано групп нь шүгэл үлээгчийн нууцлалыг батлан даах ба тогтоосон журмын хүрээнд хувийн ашиг сонирголоос ангид, үнэнч шударгаар мэдээлсэнийх нь төлөө шийтгэл оногдуулахгүй.

7 Сахилгын ШИЙТГЭЛ

Орано группийн ёс зүй ба ажил хэргийн зан төлөвийн дүрэм эсвэл бусад хүчин төгөлдөр бодлого, журмыг зөрчсөн ажилтанд сахилгын шийтгэл ногдуулна. Шийтгэл нь зөрчлийн шинж чанараас хамаарах бөгөөд группийн салбар байгууллага тус бүрт дагаж мөрдөж байгаа дотоод журмын хүрээнд сануулга өгөхөөс эхлээд ажлаас халах хүртэл арга хэмжээ авна. Салбар байгууллагын хэмжээнд ногдуулсан сахилгын шийтгэл нь хөдөлмөрийн харилцааны холбогдох хууль журамд нийцэх ёстой.

Horizontal lines for notes on page 17.

Цөмийн материалын салбарт хүлээн зөвшөөрөгдсөн Орано групп нь одоо ба ирээдүйд дэлхийн эрчим хүч болон эрүүл мэндийн салбарт тулгарах сорилтыг даван туулах шийдлийг боловсруулдаг.

Орано групп нь салбарын мэдлэг туршлага, орчин цагийн дэвшилтэт технологийг бүрэн эзэмшсэн чадвартаа суурилж үйлчлүүлэгчдээ цөмийн түлшний бүтэн эргэлтийн бүх үе шатанд өндөр үнэ цэнэ шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангадаг.

Цөмийн материалын хувиргалт ба хяналтад чиглэсэн ноу-хауг хөгжүүлэхээр ажиллаж буй Орано группийн 16,500 ажилтан дэлхийн уур амьсгал, одоо ба ирээдүйд байгалийн нөөцийг үр ашигтай зарцуулдаг дэлхийн төлөө мэдлэг, ур чадвараа зориулан аюулгүй байдлыг ханган, тасралтгүй инновацийг хөгжүүлэхээр шамдан ажиллаж байна.



The digital version of this document is compliant with the PDF/UA (ISO 14289-1), WCAG 2.1 level AA and RGAA 4.1 accessibility standards with the exception of the colour criteria. Its design enables people with motor disabilities to browse through this PDF using keyboard commands. Accessible for people with visual impairments, it has been tagged in full, so that it can be transcribed vocally by screen readers using any computer support.

Accessible PDF powered by DocAcess

